

МОНГОЛ УЛСАД ШУУД АРДЧИЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, АРГА ЗАМ

МУБИС-ийн Улс төр судлал, социологийн тэнхим

Доктор (PhD) Н.Мягмарцоож

tsooj0303@yahoo.com

У.Чөрчилл “Ардчилалд олон давуу тал бий. Гэхдээ түүнд нэг давуу тал бий одоо хүртэл хэн ч ардчиллаас дээр, давуу сайн зүйлийг бий болгоогүй” хэмээн хэлсэн байдаг. Ардчиллыг демокрасу хэмээх үгний утгад дүйцүүлэн авч үзвэл ард түмний төлөө, ард түмэн хэрэгжүүлдэг, ард түмний засаг юм. Гэвч ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжихэд хүн амын тооны өсөлт, газар нутгийн хэмжээ зэрэг хүчин зүйл хүчтэй нөлөөллийг үзүүлсээр ирсэн байдаг.

Ардчиллыг хэн эрх мэдлийг хэрэгжүүлж байна гэдгээр нь шууд /плебисцитар буюу латинаар ард түмэн/, төлөөллийн /репрезентатив буюу англиар төлөөлөл/ ардчилал хэмээн 2 хуваан авч үздэг.

XX зууны сүүлийн хагасаас дэлхийн олон улс орнуудад төлөөллийн ардчилал нь жинхэнэ ардчиллын мөн чанрыг алдагдуулахад хүргэж, ард түмэн биш харин тэднийг төлөөлж буй хүмүүс эрх мэдлийг өөрсөддөө төвлөрүүлэх явдал нилээд ихээр гарах болсон тул шууд ардчиллыг хөгжүүлэх зарим арга хэрэгсэлүүдийг /ард нийтийн санал асуулга зэрэг/ өргөнөөр ашиглах болжээ.

Монголын ардчиллын ололт, бэрхшээл

1990 оны ардчилсан хувьсгалын дараа Монгол Улсад улс төр, эдийн засгийн тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөж, нийгмийн харилцаанд ардчилсан өөрчлөлтүүд хийгдэж эхэлсэн. 1992 онд шинэ үндсэн хууль батлан гарсан нь дээрх өрчлөлтүүдийг хийхэд чухал үндэс болсон билээ.

“Freedom house”- ийн гаргасан судалгаанаас үзэхэд Монгол Улс хуучин социалист орнуудын дотор 1991 оноос хойш “эрх чөлөөт орон” болж чадсан ганц орон хэмээн дүгнэжээ¹.

Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтуудын 9 дэх нь Хүний эрхийг баталгаажуулах, Ардчилсан засаглалыг хөгжүүлэх асуудал юм.

2003 онд Монгол Улс ардчиллыг бэхжүүлэх, хүний эрх эрх чөлөөг хангахыг эрмэлзэж өөрийн орондоо Ардчиллыг Шинээр болон Сэргээн Тогтоосон Орнууд /АШТО/- ын V бага хурлыг зохион байгуулсан. Уг бага хурлаас “Улаанбаатарын тунхаглал” баримт бичгийг гаргасан бөгөөд үүнд “Ардчилсан нийгэм бол бүх талын оролцоог хангасан нийгэм мөн” гэж тодорхойлж, “Бүх талын оролцоо бүхий үндэсний хэмжээнд шийдвэр гаргах үйл явцад иргэдээ оролцох боломжоор хангах ёстой”,

¹ Ларри Даймонд, Фрэнсис Фукуяма, Стивен Краснер нарын “Монголын ээлжит сорилт” нийтлэл

“нээлттэй ил тод нийгэм орон нутгийн үндэсний болон олон улсын байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн үр нөлөөтэй оролцох боломжоор хангана”, “Бид иргэний нийгмийн байгууллагуудын хөгжих эрх зүйн болон зохицуулалтын үндсийг тавих, таатай орчин бүрдүүлэх үүрэг хүлээж байна. Бид иргэний нийгэм болон засгийн газар хоорондын түншлэлийг дэмжин урагшлуулах болно. Энэ зорилгоор бид орон нутгийн болон үндэсний түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэний нийгмийг өргөнөөр татан оролцуулах үүрэг хүлээж байна”² гэсэн үүргийг оролцогч орнууд хүлээн авсан юм.

Монгол Улсын ардчиллын хөгжлийн түүхэнд олон арван ололт амжилтыг авчирч байгаа хэдий ч дараах бэрхшээл хүндрэлүүд байсаар байгааг дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид цохон тэмдэглэсэн байна. Үүнд:

- Ардчиллын гол үнэт зүйлс болсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж, ардчилсан сонгууль будлиантаж, үндэсний болон орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо сул, нийгэмд тэгш бус байдал алдагдсаар байна.
- Төлөөллийн ардчиллыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг улс төрийн институт болох улс төрийн намуудын төлөвшил, дотоод ардчилал сул, төрийн байгууллагуудын хүнд суртал, олон шат дамжлагат байдал, авлига хээл хахууль зэрэг бэрхшээлүүд байсаар байна.
- Олон нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах үүрэг бүхий Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар зэрэгт итгэх иргэдийн итгэл төдийлөн сайжрахгүй байгаа тэдгээрт хариуцлага тооцох механизм төдийлөн хэрэгжихгүй байна.

Монгол Улсад шууд ардчиллыг хөгжүүлэх боломж, арга зам

Монгол Улсад Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд: *Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ* хэмээн заасан байдаг. Энэ заалт нь Монгол Улсад шууд болон төлөөллийн ардчиллыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж буй учир үндэсний түвшинд (УИХ, ЗГ) төлөөллийн ардчиллын зарчмыг, орон нутгийн түвшинд шууд ардчиллын зарчмыг түлхүү хэрэгжүүлэх (ялангуяа баг хорооны иргэдийн нийтийн хурлын түвшинд) нь ардчиллын хөгжил дэх чухал хувь нэмэр болно хэмээн харж болохоор байгаа юм.

Монгол Улсад шууд ардчиллыг хөгжүүлэхэд дараах 3 арга замыг сонгон хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Шууд ардчиллыг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Энэхүү арга замыг хэрэгжүүлэхэд 1- рт холбогдох зарим хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах, 2- рт бие даасан зарим хуулиудыг батлан гаргах шаардлагатай байна.

² Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл

- ❖ Монгол Улсын Засаг захиргаа, удирдлагын нэгж түүний удирдлагын тухай хуулинд орон нутгийн түвшиний бодлого шийдвэрийг төлөвлөх, хэлэлцэх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх үйл явцад иргэдийн оролцох боломжийг бүх талаар хангадаг байх, нийтийн эрх ашигтай холбоотой асуудлыг шийдвэрлэх эрхийг баг, хорооны иргэдийн нийтийн хуралдолгох нь зүйтэй. Ялангуяа орон нутгийн төсөв, тендер, байгалийн баялаг эзэмших, ашиглах, орон нутагт нийтээр мөрдөх дүрэм журамзэргийг олон нийтийн шууд оролцоотой шийдвэрлэдэг байх.
- ❖ Ард нийтийн санал асуулгаар зайлшгүй шийдвэр, асуудал гэж оруулах.
Үүнд: Санал асуулгыг төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар ард нийтийн сонголт хийлгэх шаардлага гарсан тохиолдолд;
Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар;
Стратегийн орд газрын байгалийн баялагыг ашиглах, эзэмших, экологийн тэнцвэрт байдал алдагдуулахаар болон алдагдуулж буй аливаа асуудлыг шийдвэрлэхэд;
Нийтийн эрх ашиг, сонирхолын асуудлаар Улсын Их Хурал, Засгийн Газар, Ерөнхийлөгчийн хоорондын байр суурийн зөрөө гарсан үед;
Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд сөргөөр нөлөөлж болохуйц олон улсан гэрээ, конвенцид нэгдэн ороход;
Гадаадын аль нэгэн улс орноос үндэсний нийт бүтээгдэхүүнээс илүү гарсан зээл тусламжийг авах үед; тус тус явуулдаг болох
- ❖ Ард нийтийн санал асуулгын хэлбэрийг цахим болон асуулгын хуудас ашиглан бүх шатны сонгуультай хамт, эсвэл тусад нь хийдэг байх.
- ❖ Ард нийтийн санал асуулгыг үндэсний болон орон нутгийн түвшинд хийдэг болох шаардлагатай байна.
- ❖ *Бие даасан хуулиудыг батлан гаргах /Нээлттэй хурлын тухай хууль, Ил тод байдлын тухай хууль/*

Хоёр. Иргэдийн шууд оролцооны бүтцийг бий болгох.

Оролцооны бүтцийг бүрдүүлэхийн тулд 1-рт оролцооны асуудал хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтан, салбар, хэлтэстэй байх, 2- рт иргэдийн оролцоог хангах бүтцүүдийг бий болгох хэрэгтэй. Тухайлбал:

- ❖ *“Иргэний зөвлөл”* байгуулах - Иргэний зөвлөл нь чөлөөт ардчилсан зарчмын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн төрийн бус, иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн сайн дурын нэгдэл мөн бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн нэгж болон иргэдийн харилцаа, түншлэлийг бэхжүүлэх, төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрт гишүүд дэмжигчид, нийтийн санаа бодлыг тусгуулах, тэдний эрх ашиг сонирхолыг илэрхийлэн хамгаалах үүргийг хүлээнэ.
- ❖ *“Иргэний зөвлөл хороо”* ажиллуулах - “Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл 2011”- ийн бодлогын үндсэн зөвлөмжид “шийдвэр гаргах бүх түвшинд иргэдийн оролцох эрх мэдлийг нэмэгдүүлэх”- ийг зөвлөсөн байна. Мөн цаашлаад аймаг, сумдын түвшинд “Байгаль орчны асуудлаарх Иргэний зөвлөл”- ийг байгуулах

болон “Хүний аюулгүй байдлын асуудлаарх оролцогч талуудын бүлэг”- ийг байгуулах хэрэгтэй. Энэ нь хүний аюулгүй байдлыг сайжруулах, нийгэм, байгаль орчны тогтвортой байдлыг хангах суурь нөхцөл болно гэжээ.

- ❖ “*Иргэний танхим*” – Иргэний танхимыг бүх түвшинд ажиллуулах хэрэгтэй. Иргэний танхимыг зөвхөн улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагааны өмнө биш иргэдийн өмнө тулгарсан асуудал бэрхшээлийг шийдвэрлэх, нийтийн эрх ашигтай холбоотой бүх асуудлыг хэлэлцүүлэхэд нээлттэй байлгах.
- ❖ “*Нээлттэй хэлэлцүүлэг*” – Иргэд, олон нийт өөрсдийн болон нийтийн эрх ашигтай хамааралтай бүхий асуудлаар чөлөөтэй ярилцах, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг бий болгох. Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах үед баримтлах дүрэм журам чхал байдаг.
- ❖ “*Нээлттэй сонсгол*” – бодлого шийдвэрт ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэдийн саналыг тусгах, мэдээлэл авах болон хэрэгжиж буй бодлого, шийдвэрийн үр дүнг шалгах зорилгоор нээлттэй сонсголыг шийдвэр гаргагчдын зүгээс зохион байгуулдаг.

Гурав. Иргэдтэй ажиллах тэдний шууд оролцоог хангах менежментийг сайжруулах

- Олон нийтэд тэгш хүртээмжтэй, хялбар, хэрэгцээтэй мэдээлэл цаг алдалгүй очдог байх зарчмыг баримтлах,
- Иргэдийн оролцоонд боломжтой бүх арга хэрэгслүүдийг ашиглах боломжийг бүрдүүлэх (утас, цахим хуудас, шуудан ашиглах, өргөдөл гомдол санал захиа бичих г.м),
- Олон нийттэй харилцах менежмент, ур чадварт төрийн байгууллага албан тушаалтныг бэлтгэх,
- ТББ, Иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулах,
- Зарим улс орнуудын туршлагыг өөрийн улс орны онцлогт тохируулан хэрэглэх шаардлагатай байна.

Ном зүй

1. Иргэн таны оролцоо – Ардчиллын баталгаа. 2005. Уб: УТБА.
2. Марк Грамбергер. 2003. Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах. Уб: ННФ.
3. Мягмарцоож. Н. 2012. Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо. Уб: МУБИС.
4. Судалгааны ажлууд ба төгслийн баримт бичгүүдийн эмхэтгэл. 2003. Уб: АШСТО-ын V Бага Хурал.
5. Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь ардчилал, засаглалын төлөв байдал, үнэлгээ. 2006, 2008, 2010. Уб: НҮБХХ, ШУА-ийн ФСЭХ.
6. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
7. Ард нийтийн санал асуулгын тухай хууль. 1995 он
8. Монгол Улсын Засаг захиргаа, удирдлагын нэгж түүний удирдлагын тухай хууль. 2006 он